




УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу төлөвлөж,
бүрдүүлсэн ч, хууль, журамд заагдаагүй удирдлагыг хэрэгжүүлэх
урсгал зардал гаргасан байна.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалт

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	1-2
Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд	Товчилсон үгийн тайлал	3
Аудитын менежер Ж.Энхжаргал	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	Үндсэн мэдээлэл	5
Ахлах аудитор С.Алтанхундага	Бүлэг 1: Аймгийн ОНХС-аас сумдад олгох шилжүүлгийг журамд заасан итгэлцүүрээр тооцсон ч тодотгол хийхдээ харилцан адилгүй танаж баталсан байна.	6
Ахлах шинжээч М.Батсуурь		6
Аудитор Т.Намжил	1.1 ОНХНС-аас Увс аймагт 3873,9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор төлөвлөсөн байна.	6
	1.2 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан 3 нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.	6-7
	1.3 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан 3 нэр төрлөөр бүрдүүлсэн байна.	7-10
2016 оны 5 дугаар сар	1.4 Аймгийн ОНХС-аас сумдад олгох шилжүүлгийг журамд заасан итгэлцүүрээр тооцсон ч тодотгол хийхдээ харилцан адилгүй танаж баталсан байна.	10
	<i>Дүгнэлт</i>	10
	<i>Зөвлөмж</i>	10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3721, 7045-3799 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 2: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс хууль, журамд заагдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, зарцуулсан байна.	10-11
	2.1 ОНХС- ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэсэн байна.	11-12
	2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч, эрэмбэлсэн байна.	12
Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3-р баг Аймгийн Засаг даргын тамгын газрын байр	2.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.	12-13
	2.4 Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахдаа Засгийн газрын 2013 оны 68 тоот тогтоолоор баталсан шууд худалдан авч болох жишиг	

үнийг баримтлаагүй байна.	13-16
2.5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгт тусгагдаагүй төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.	16-18
2.6 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгосон байна.	18-19
2.7 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	20
<i>Дүгнэлт</i>	20
<i>Зөвлөмж</i>	22
<u>Бүлэг3:</u> ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.	21
3.1 ОНХС-ийн хэрэгжилтийн явцад аймгийн ИТХ-ийн дэргэдэх хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт хийгээгүй, дотоод аудитын алба хяналт шалгалт хийсэн байна.	21-22
3.2 Сумууд ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу ирүүлээгүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.	23
3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн байна.	24
3.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжийн зарим заалттай нийцэхгүй байна.	23-24
3.5 Өмнөх оны аудитаар өгсөн актыг 100 хувь, албан шаардлагыг 85.7 хувь, зөвлөмжийг 50 хувь хэрэгжүүлсэн байна.	25
<i>Дүгнэлт</i>	25
<i>Зөвлөмж</i>	26
<i>Санал асуулгын нэгтгэл</i>	27-29
<i>Холбогдох байгууллагын санал</i>	30
<i>Аудитын газраас өгөх тайлбар</i>	

Товчилсон үгийн тайлал:

1	ҮАГ	Үндэсний аудитын газар
2	УВААГ	Увс аймгийн Аудитын газар
3	НА	Нийцлийн аудит
4	СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
5	ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
6	ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
7	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
8	НББ	Нягтлан бодох бүртгэл
9	ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
10	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
11	СС	Сангийн сайд
12	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
13	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
14	ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
15	ТББ	Төрийн бус байгууллага
16	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
17	ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
18	ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
19	ХХЦГ	Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газар
20	АШУИС	Ангаахын шинжлэх ухааны их сургууль

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал зөвлөмж боловсруулан аудитын дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ.

Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх.

3. Хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан, аймаг сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, ОНӨГ, Баг, хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг хамруулав.

4. Арга зүй

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох баримт бичиг, бусад зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Нийцлийн аудитыг аймгийн Аудитын газрын ахлах аудитор С.Алтанхундага, ахлах шинжээч М.Батсуурь, аудитор Т.Намжил нар хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Монгол улсын 2016 оны төсвийн тухай хуульд ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэгийн хэмжээг 131.0 тэрбум төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар 120.3 тэрбум төгрөг болгон өөрчилжээ.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдөж байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Увс аймагт 2016 онд 3040.6 сая төгрөг хуваарилагдсанаас аймгийн ОНХСанд 1485.2 сая, сумдын ОНХСанд 1555.4 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Бүлэг1: Аймгийн ОНХС-аас сумдад олгох шилжүүлгийг журамд заасан итгэлцүүрээр тооцсон ч тодотгол хийхдээ харилцан адилгүй танаж баталсан байна.

1.1. ОНХС-аас Увс аймагт 3873,9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор төлөвлөсөн байна.

Монгол улсын 2016 оны төсвийн тухай хуульд тусгагдсанаар ОНХС-аас Увс аймагт 3873.9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилахаар анх баталсан байна. Гэтэл Монгол улсын 2016 оны төсвийн тухай хуулийн тодотголоор өөрчлөлт оруулж дараах байдалтай хуваарилахаар төлөвлөсөн байна. Үүнд:

Эх үүсвэр	Анх баталсан	Тодотголоор	/сая төгрөгөөр/ Хуваарилсан
			Хуваарилсан
ОНХС-аас	3873,9	3040,6	3040,6

Төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан анх төлөвлөснөөс 833.3 сая төгрөгөөр буурчээ.

1.2. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан 3 нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.1, 6.2-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны ОНХС-ийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөхөөр тусгасан байна. Үүнд:

- ОНХС, ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр
- Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр
- Тухайн орон нутгийн орлогыг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив тусламж

Увс аймгийн ОНХС-ийн эх үүсвэрт 2016 онд ОНХС-аас 1879.8 сая, өмнөх оны үлдэгдлээс 201.9 сая, орон нутгийн орлогоос 242.0 сая, нийт 2323.7 сая, сумдын ОНХС-ийн эх үүсвэрт 2016 онд аймгийн ОНХС-аас 1994.1 сая, өмнөх оны үлдэгдлээс 170.9 сая, орон нутгийн орлогоос 23.8 сая, дотоод гадаадын хандив тусламж болон бусад орлого 54.7 сая, нийт 2243.5 сая төгрөгийн эх үүсвэр төлөвлөсөн байна.

1.3. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан 3 нэр төрлөөр бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60.2-д Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заажээ. [/2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2 эх үүсвэрийг хүчингүй болгосон байна./](#)

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг
- Энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө
- Орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг хасч үлдэх хэсэг
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь

Увс аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг ОНХНС-аас олгох шилжүүлэг, орон нутгийн орлого, өмнөх оны үлдэгдэл, бусад орлогоос бүрдүүлсэн байна. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн бүрдүүлэлт дараах байдалтай байна.

№	Орлогын нэр төрөл	Аймаг	Сум
1	ОНХНС	1485.2	1555.4
2	Орон нутгийн орлого	242.0	23.8
3	Бусад орлого	0.05	66.5
4	Өмнөх оны үлдэгдэл	202.6	170.9
	Нийт дүн	1929,8	1816.6

1.4. Аймгийн ОНХС-аас сумдад олгох шилжүүлгийг журамд заасан итгэлцүүрээр тооцсон ч тодотгол хийхдээ харилцан адилгүй танаж баталсан байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1-р хавсралтаар баталсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 9.2-д "Аймаг нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилахад энэ аргачлалын 3 дугаар зүйлд заасан мэдээллийг ашиглан мөн аргачлалын 4-8 дугаар зүйлд заасан итгэлцүүрүүдийг орон нутгийн үзүүлэлтэд дүйцүүлэн тогтооно" гэж заажээ.

Дээрх заалтыг зөрчиж 2016 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д хуваарилсан 3040.6 сая төгрөгийн 48.8 хувь буюу 1485.2 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 51.2 хувь буюу 1555.4 сая төгрөгийг 19 сумын ОНХС-д тус тус хуваарилсан байна.



Төсвийн тухай хуулийн 59.3-д аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг төлөвлөхөд шаардлагатай итгэлцүүрийг тодорхой тусгасан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн индекс
- Хүн амын тоо
- Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ
- Орон нутгийн татварын идэвх санаачилга

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” журмын 1-р хавсралтанд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 3.2-т орон нутгийн хөгжлийн индекс 25 хувь, хүн амын тоо 25 хувь, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ 25 хувь, орон нутгийн татварын идэвхи санаачилга 25 хувиар орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тооцож төлөвлөхөөр тусгажээ.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох эх үүсвэрийг төлөвлөж, хуваарилахдаа Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1-р хавсралтын 9.4-д “Энэ аргачлалын 3.2.1-д заасан орон нутгийн хөгжлийн индексийг сум, дүүргийн түвшинд үнэн зөв, бодитой байдлаар гаргах боломжтой болох хүртэлх хугацаанд уг индексэд харгалзах 25 хувийг аргачлалын 3.2.2-3.2.4-т заасан үзүүлэлтүүдэд тэнцүү хуваарилах байдлаар орлуулан хэрэглэж болно” гэж заасны дагуу сумын хөгжлийн индексийг хасаж үлдсэн 3 итгэлцүүрт тэнцүү буюу 33 хувиар тооцсон байна.

Аймгийн ОНХС-аас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгосон шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.3 дахь заалт, дээрх журамд заасан 3 итгэлцүүрээр тооцсон ч нийлбэр дүнг гаргахдаа зарим сумыг нэмэгдүүлж, зарим сумыг бууруулсан байна.

Д/д	Сумдын нэр	Хүн амын тооноос хамаарах дүн	Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрээс хамааруулан	Татварын идэвхи санаачлагаас хамааруулан	Нийт дүн /сая.төг/	Хуваарьт дүн /сая.төг/	Зөрүү
1	Баруунтуруун	21.5	35.7	30.5	87.7	86.7	1
2	Бөхмөрөн	18.4	39.5	41.5	99.4	98.7	0.7
3	Давст	13.8	63.4	29.5	106.7	101.3	5.4
4	Завхан	15.2	64.8	39.6	119.6	111.7	7.9
5	Зүүнговь	23.2	35.1	32.7	91.0	90.0	1
6	Зүүнхангай	18.5	44.9	36.7	100.1	99.5	0.6
7	Малчин	20.6	34.4	30.3	85.3	84.2	1.1
8	Наранбулаг	35.3	34.4	37.9	107.6	107.3	0.3
9	Өлгий	18.8	25.0	34.4	78.2	76.9	1.3
10	Өмнөговь	36.8	26.2	37.1	100.1	99.5	0.6
11	Өндөрхангай	26.6	48.7	30.4	105.7	105.3	0.4
12	Сагил	19.3	29.6	41.9	90.8	89.9	0.9
13	Тариалан	32.6	22.6	35.5	90.7	89.8	0.9
14	Түргэн	17.7	18.3	28.2	64.2	75.3	-11.1
15	Тэс	44.4	27.3	37.5	109.2	108.9	0.3
16	Ховд	19.6	34.6	39.8	94.0	92.2	1.8
17	Хяргас	20.3	34.2	37.8	92.3	91.4	0.9
18	Цагаанхайрхан	17.6	45.8	28.8	92.2	91.3	0.9
19	Улаангом	244.4	0.1	34.7	279.2	294.1	-14.9
Нийт		664.7	664.7	664.7	1994.0	1994.0	0

Дээрх судалгаанаас үзэхэд ОНХС-ийн орлогын шилжүүлгийн тооцоолол хийхдээ Улаангом суманд 14.9 сая, Түргэн суманд 11.1 сая, нийт 26.0 сая төгрөг илүү бусад сумдад 0.3-7.9 сая хүртэл төгрөг буюу нийт 26.0 сая төгрөг дутуу хуваарилахаар тооцсон байна.

Монгол улсын төсөв санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Увс аймгийн ОНХСанд олгох орлогын шилжүүлэг анх батлагдсан дүнгээс 833.3 сая төгрөгөөр дутуу хуваарилагдсан байна.

ОНХНС эх үүсвэрээс олгох орлогын шилжүүлэг дутуу ирснээс сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг 438.7 сая төгрөгөөр танасан бөгөөд сумдаас харилцан адилгүй хувь хэмжээгээр бууруулсан нь ямар аргачлалаар тооцсон нь тодорхойгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалт

Д/д	Сумдын нэр	Анх баталсан дүн /сая.төг/	Танасан дүн /сая.төг/	Танасан хувь	Олгосон санхүүжилтийн дүн
1	Баруунтуруун	86.7	27.1	31	59.6
2	Бөхмөрөн	98.7	30.7	31	68.0
3	Давст	101.3	31.3	31	70.0
4	Завхан	111.7	34.6	31	77.1
5	Зүүнговь	90.0	27.8	31	62.2
6	Зүүнхангай	99.5	30.9	31	68.6
7	Малчин	84.2	25.5	30	58.7
8	Наранбулаг	107.3	32.6	30	74.7
9	Өлгий	76.9	0.0	0	76.9
10	Өмнөговь	99.5	0.0	0	99.5
11	Өндөрхангай	105.3	32.2	31	73.1
12	Сагил	89.9	27.8	31	62.1
13	Тариалан	89.8	27.7	31	62.1
14	Түргэн	75.3	29.2	39	46.1
15	Тэс	108.9	34.0	31	74.9
16	Ховд	92.2	28.3	31	63.9
17	Хяргас	91.4	0.0	0	91.4
18	Цагаанхайрхан	91.3	0.0	0	91.3
19	Улаангом	294.1	19.1	6	275.0
Нийт		1994.0	438.7		1555.31

Судалгаанаас үзэхэд Өлгий, Өмнөговь, Хяргас, Цагаанхайрхан сумдаас огт танаагүй бөгөөд Улаангом сумаас 6 хувь, бусад сумдаас 30-39 хувиар танасан байгаа нь Засгийн газрын 2012 оны 30 тоот тогтоолоор баталсан “ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг зөрчсөн байна.

Шалтгааныг тодруулахад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд тулгуурлан тодотгол хийж хуваарилсан гэсэн тайлбар өглөө.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг журамд заасан итгэлцүүрээр тооцсон ч нийлбэр дүнг өөрчлөн баталсан байна.
2. ОНХС-аас сумдад олгох шилжүүлэгт тодотгол хийхдээ ажлын гүйцэтгэлд тулгуурласан гэх шалтгаанаар харилцан адилгүй танаж баталсан байна.
3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д хуваарилсан 3040.6 сая төгрөгийн 48.8 хувь буюу 1485.2 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 51.2 хувь буюу 1555.4 сая төгрөгийг 19 сумын ОНХС-д хуваарилсан байна.

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Зөвлөмж: Увс аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.3, Засгийн газрын 30-р тогтоолын дагуу баталж хуваарилах.

Бүлэг 2: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс хууль, журамд заагдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, зарцуулсан байна.

2.1. ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэсэн байна.

Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэсэн байна.


Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 2.2-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь УИХ, Засгийн газар болон тухайн орон нутгийн хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, түүнтэй холбогдох бусад бичиг баримттай уялдсан байна” гэж заажээ.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг Увс аймгийг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан тодорхойлж аймгийн ИТХ-аар батлуулан ажиллажээ.

Харин сумдын хувьд хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зарим зүйл заалтаар тодорхойлогдож байна.

Увс аймгийн хэмжээнд 2016 онд аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр 24, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр 236 буюу нийт 260 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар баталжээ.

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс аймгийн ИТХ-ын 2008 оны 08/01 тоот тогтоолоор баталсан “Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр /2008-2021 он/-т тусгагдсан орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй 226 төсөл, арга хэмжээ буюу 87 хувь нь уялдсан байна. Графикаар харуулбал:



2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч, эрэмбэлсэн байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар баталсан журмын 12.1-д “Аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэд олон нийтийн саналыг цахим хуудас, санал асуулгын хуудас ашиглах, ярилцлага зохион байгуулах болон дэвшилтэд технологийн бусад хэлбэр ашиглах замаар явуулна”, 12.2-т “Сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэд олон нийтийн оролцоог санал асуулгын хуудас ашиглах, бүлгийн ярилцлага, цахим хэлбэрээр авна” гэж заажээ.

Ихэнх сум ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх болон хийсэн ажлын жагсаалтыг гарган санал асуулгын хуудас дээр хэвлэж хүргүүлэх, багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн санал авч, эрэмбэлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэс сумдаас эрэмбэлж ирүүлсэн саналыг авч чиглэл, чиглэлээр нэгтгэжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө www.uvs.gov.mn цахим хуудсаар нээлттэй санал авсан байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар баталсан журмын 12.1.3-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн иргэд олон нийтэд танилцуулна”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан зааврын 6.6-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, олон нийтээс хамгийн их санал авсан, ажлын хэсгийн санал дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн иргэд, олон нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон иргэний танхимаар дамжуулан 11 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулна” гэж заажээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн урьдчилсан саналын жагсаалтыг иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлсэн байна.

Өмнөговь, Бөхмөрөн сум иргэдээс шинээр санал авахгүйгээр өмнөх онуудад иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлсэн байна.

2.3. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан зааврын 4.7-д “Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” гэж заажээ.

Аймаг, сумууд ОНХС-ийн эх үүсвэрээсээ өмнөх онд хийгдсэн ажлын санхүүжилтийн үлдэгдэл өр төлсөн, он дамжин хийгдсэн ажлыг санхүүжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн зураг төсвөө батлуулсан хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана”, Барилгын тухай хуулийн 15.2-д “Зураг төсөвгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно” гэж заажээ.


Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд шинээр хэрэгжүүлэхээр 11 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна. Үүнээс аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас худалдан авах ажиллагааг зохион байгуулсан Улаангом сумын 12-р багийн Гашууны 11-р хороолол, хуучин Дулааны станцын урд задгай хороолол, Гахайн байрны доод хэсэг, 10-р багийн дунд хорооллын доод хэсгийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөний ажлын ТЭЗҮ, зураг төсөв батлагдсан байна.

2.4. Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахдаа Засгийн газрын 2013 оны 68 тоот тогтоолоор баталсан шууд худалдан авч болох жишиг үнийг баримтлаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.3, 47.6 дахь заалтуудаар үнэлгээний хороонд тавигдсан шаардлагыг хангасан ажилтны нөөц боломж сум, орон нутагт дутагдалтай байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд ОНХСангийн хөрөнгө оруулалтаар шинээр хийгдсэн төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулаагүй бөгөөд гүйцэтгэгчийг дараах байдлаар сонгон шалгаруулсан байна.

Худалдан авах ажиллагаа



Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-аар шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 10.0 сая төгрөг байхаар тогтоосныг зөрчсөн байна. Тухайлбал:

- Зүүнхангай сум өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 15.0 сая
- Цагаанхайрхан өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 23.2 сая, малжуулах төсөл 25.0 сая
- Давст сум өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 19.7 сая,
- Наранбулаг сум өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 15.9 сая
- Өлгий сум малжуулах төсөл 18.0 сая
- Хяргас сум малжуулах төсөлд 21.0 сая
- Түргэн сум өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 14.8 сая
- Тэс сум өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 14.2 сая
- Ховд сум малжуулах төсөл 20.0 сая
- Малчин сум өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 20.0 сая
- Өмнөговь сум Баянгол багийн эрчим хүч 30.0 сая, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 20.0 сая, малжуулах төсөл 23.0 сая, сийланта хөтөлбөр 10.8 сая, нийт 83.8 сая

Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолд заасан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг албан шаардлага болголоо.

ТБОНӨХБАҮХАТ-ын хуулийн 11-р зүйлд “Захиалагч техникийн тодорхойлолт бэлтгэхэд тавигдах шаардлагыг тодорхой тусгасан байна” гэж заасан байхад бараа худалдан авах гэрээ, техникийн нөхцөлд нийлүүлэх ажил, үйлчилгээний нэр, тоо ширхэг, үнийг тодорхой тусгаагүй байгаа нь дээрх заалттай зөрчилдөж байгаа ба өндөр үнэтэй, чанаргүй бараа нийлүүлэх эрсдэл үүсэж байна. Тухайлбал:

- Өмнөговь сумын Ахлах сургуульд ОНХС-ийн эх үүсвэрээр хатуу, зөөлөн эдлэл нийлүүлэхдээ худалдан авах ажиллагааг хуурамч баримт бүрдүүлэн хийж техникийн тодорхойлолтонд 20 ширхэг хуучин төмөр орыг 1.0 сая төгрөгөөр авахаар тусгаж, худалдан авсан байна. Аудитын явцад үзэхэд тухайн орнууд хэт хуучин байх бөгөөд ашиглагдахгүйгээр складанд хадгалагдаж байна. Цаашид ТБОНӨХБАҮХАТ-ын хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөж байна. Түүнчлэн бичиг баримт хуурамчаар үйлдэж чанаргүй бараа худалдан авсан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.
- Цагаанхайрхан сум ОНХС-ийн эх үүсвэрээс 12.0 сая төгрөгөөр ЭМТ-д тоног төхөөрөмж авахаар төлөвлөсөн байна. Тухайн хөрөнгийн бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээнд тухайн хөрөнгийн санхүүжилтийг бүрэн төлсөн үед нийлүүлэх заалт оруулсанаас тухайн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан боловч биетээр ирээгүй зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага болголоо.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнээс аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны 2016 оны тайлан, мэдээг шаардахад 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр ажил хүлээлцэхдээ мэдээ тайлан өгөөгүй, компьютерийг форматласан хэрэгцээт файл, тайлангууд байхгүй байсан гэсэн тайлбар өгсөн.

2.5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгт тусгагдаагүй төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”,

Сангийн сайдын 2014 оны 43 тоот зааврын 4.2-д “Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн ажлыг төлөвлөгөөнд тусгана” гэж заасан байхад аймаг, сумдын ОНХС-аас хуулиар тогтоосон чиг үүрэгт байхгүй, багийн иргэдээс санал аваагүй зарим ажлыг эрэмбэлж, төлөвлөгөөнд тусган санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

Аймгийн ОНХС-аас :

- Жангар мөрөн ХХК-д шүүхийн шийдвэрийн дагуу 26.2 сая

Сумдын ОНХС-аас:

- Завхан сум начинны алдар тэмдэглэхэд 1.0 сая
- Малчин сум ОНХС-аас хийгдэх ажлыг ИТХ-аар батлахдаа “бусад” гэсэн нэрээр 5.9 сая
- Сагил сумын ойн зардлын өр төлөхөд 7.7 сая /ойн хандивын үлдэгдлээс/
- Тариалан сумын 90 жилийн ой тэмдэглэхэд өр 4.2 сая /ойн хандивын үлдэгдлээс/

Төсвийн тухай хуулийн 6.3.4-д “Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, 60.3.5-д ОНХС-ийн хөрөнгийг “Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, **хохирлыг нөхөн төлөх** үүрэг авах”, 60.3.6-д “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно” гэж заасны дагуу зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг албан шаардлага болгов.

Мөн ОНХС-ийн эх үүсвэрээс малын гоц халдварт өвчин мялзан төст өвчний зардалд Өлгий сум 2.8 сая, Өмнөговь сум 6.2 сая төгрөг зарцуулсныг аудитын явцад УАГ-ын өгсөн чиглэлийн дагуу санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв.

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн эх үүсвэрээс хөтөлбөр, төсөл баталж урсгал зардал гаргасан байна. Тухайлбал:

- Боловсрол хөтөлбөрийн хүрээнд 1000 багшийн зөвлөгөөнд 30.0 сая, Авьяас уралдаанд 10.0 сая, анги нийтийн олимпиад 10.0 сая, сонгодог хөгжмийн уралдаанд 6.5 сая, “Миний Увс боловсрол” сэтгүүл хэвлүүлэхэд 6.5 сая, нийт 60.0 сая
- Эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд Гелюдиагизийн эмч мэргэжилтэнүүдийг Тайван улсад мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг 4.4 сая, “СИЙЛАНТ” арга хэмжээний эмч нарын томилолт 2.4 сая, эрт илрүүлэлтийн аянд 6.7 сая, хүүхдэд ээлтэй эмч мэргэжилтэн шалгаруулах аянд 1.5 сая, нийт 15.0 сая
- Спортын дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит болон аймгийн аварга шалгаруулах жүдо, чөлөөт, үндэсний бөх, хөл бөмбөгийн тэмцээнд нийт 30 сая

Улаангом сумын ОНХС-аас төсөл, хөтөлбөр нэрээр дараах урсгал зардал санхүүжүүлсэн байна. Үүнд:

- “Албан бус боловсрол” хөтөлбөрийн хүрээнд 8 ханатай бүрэн сийлбэртэй гэр авахад 7.0 сая, “Улаангом дэвжээ” ТББ-д дэмжлэг 1.0 сая, Цогцолбор 1-р сургуульд хөдөлмөр зуслан нэрээр 2.0 сая төгрөг өгсөнийг байгууллагын ойн үйл ажиллагааны зардлын өр төлсөн, нийт 10.0 сая
- “Улаангом-330” төслийн хүрээнд “Миний хайртай улаангом” ТББ-д “Миний хайртай Улаангом аян” хэрэгжүүлэхэд урамшуулал, зар сурталчилгаа, бичиг хэрэг, шатахуун, нэгжний зардалд нийт 3.0 сая, элс, хайрганы үнэ 1.2 сая, засварын материал 0.8 сая, нийт 5.0 сая

Дээрх төсөл, хөтөлбөрүүдийн талаар аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдээс тодруулахад аймгийн “Боловсрол” хөтөлбөрийг 2017 онд боловсруулсан байна. “Эрүүл мэнд хөтөлбөр” байхгүй, эрүүл мэндэд чиглэсэн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн, өмнө нь “Боловсрол”, “Спортын дэд хөтөлбөр” байсан эсэхийг мэдэхгүй ажил хүлээлцэхэд өгсөн зүйл байхгүй гэсэн тайлбар өгсөн.

Улаангом сумын холбогдох мэргэжилтнээс тодруулахад “Боловсрол”, “Авьяас”, “Эрүүл мэнд”, “Улаангом-330”, “Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх” зэрэг төсөл, хөтөлбөрүүд байхгүй бөгөөд “Баялаг бүтээгч Улаангом хөтөлбөр /2015-2025/-ийн хүрээнд болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан чиглэлээр зарцуулсан гэсэн тайлбар өгсөн.

Цаашид ОНХС-аас хуулиар тогтоосон чиг үүрэгт байхгүй, багийн иргэдээс санал аваагүй, урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр төлөвлөж, батлахдаа хууль, журмаар зөвшөөрөгдсөн хүрээнд ямар ажилд зарцуулахыг тодорхой тусгаж байхыг албан шаардлага болгов.

Зарим сумд Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр бэлтгэсэн өвс, тэжээлийг үнэ төлбөргүй болон 50 хувийн хямдралтай олгосон зөрчил байна.

Тухайн оны Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төлөвлөхдөө өвсний фонд, аюулгүйн фонд нэрээр иргэдийн саналыг үндэслэн холбогдох хууль, журам зааврын хүрээнд өвс, тэжээл бэлтгэсэн байна. Гэтэл зудтай аймаг, сумдад өвс тэжээл олгох Засгийн газрын 2015 оны 480 тоот, 2016 оны 67 тоот тогтоолыг үндэслэн тухайн сумын ИТХ-ын тогтоолоор өвсийг үнэ төлбөргүй, тэжээлийг 50 хувийн хямдралтай олгохоор шийдвэрлэжээ.

Сумдын ИТХ-ын өвс, тэжээлийг үнэгүй болон хямдралтай үнээр олгох тогтоол, захирамжуудын үндэслэх заалтууд нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 18.1.2, 29.1.3-ын “а”, 29.2, Гамшгийн тухай хуулийн 26.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн тогтоол, шийдвэрүүд гаргасан байна.

Тухайн хууль тогтоомжийг судлаж үзэхэд сумын ИТХ, Засаг даргын чиг үүрэгт хамаарч байгаа тул Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалын 4.6 дахь заалт, төлбөрийн акт тогтоох албан шаардлага өгөх журмын 4.1.7 дахь заалтуудыг үндэслэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг албан шаардлага болгож байгаа талаар УАГ-т албан тоот хүргүүлэн чиглэл авсан болно. Иймд цаашид ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй олгох асуудлыг таслан зогсоохыг албан шаардлага болголоо. Үүнд:

- Улаангом сум үнэгүй тараасан өвс 12.3 сая, хямдруулан борлуулсан тэжээл 4.8 сая
- Өндөрхангай сум үнэгүй тараасан тэжээл 6.3 сая
- Цагаанхайрхан сум хямдруулсан тэжээл 9.2 сая
- Давст сум үнэгүй тараасан өвс 9.8 сая
- Өлгий сум үнэгүй тараасан өвс 10.5 сая, хямдруулсан тэжээл 4.9 сая
- Сагил сум үнэгүй тараасан тэжээл 20.0 сая
- Түргэн хямдруулсан тэжээл 8.0 сая
- Тэс сум үнэгүй тараасан тэжээл 14.2 сая
- Өмнөговь сум үнэгүй тараасан тэжээл 20.0 сая
- Хяргас сум үнэгүй тараасан тэжээл 15.0 сая
- Баруунтуруун сум үнэгүй тараасан тэжээл 10.0 сая

Тухайн асуудал нь Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалтыг зөрчиж байгаа бөгөөд буруутай шийдвэр гарган ОНХС-ийн хөрөнгийг үнэ төлбөргүй болон, хямдруулан олгосон эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцох үндэслэлтэй байна. Шалгалтанд хамрагдсан 2016 онд орон нутгийн ИТХ-ын ээлжит сонгууль болсонтой холбоотойгоор сумдын удирдлагууд солигдсон байх тул хариуцлагын санал хүргүүлээгүй болно.

Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасан байхад зарим сумууд ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн өвс тэжээлийг иргэдэд зээлээр олгон авлагаар бүртгэсэн байсанд авлагыг барагдуулах зөвлөмж өглөө. Үүнд :

- Бөхмөрөн сум 3.1 сая
- Өлгий сум 6.0 сая
- Цагаанхайрхан сум 4.9 сая
- Түргэн сум 3.2 сая
- Ховд сум 2.4 сая
- Зүүнговь 10.0 сая
- Завхан сум 5.8 сая
- Сагил сум 3.0 сая

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан журмын 4.4-д “Аймаг, сумын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахгүй байх” гэж заасныг зөрчин аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээс дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг албан шаардлага болгов. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээс Дулааны 2-р станцад /цахилгаан дулаан хангамж/ 150.0 сая
- Зүүнхангай сум өвс тэжээлийн тээврийн зардалд 3.1 сая
- Түргэн сум “Олон улсын язгуур урлагын наадам”-д 5.0 сая
- Цагаанхайрхан сум гэржүүлэх төсөл 7.0 сая
- Өлгий сум гэржүүлэх төсөл 8.0 сая
- Баруунтуруун сум газрын генераторын түлш 2.8 сая
- Малчин сум өвс тэжээл ачиж ирсэн тээврийн зардалд 2.0 сая, ачиж, буулгах хөлс 1.0 сая, нийт 3.0 сая
- Завхан сум ОНХС-ийн дансанд байсан ойн хандиваас өвс, тэжээлийн тээврийн зардалд 1.4 сая
- Малчин сум ОНХС-ийн эх үүсвэрээс бэлтгэсэн өвс, тэжээл борлуулсны орлого 10.0 сая төгрөгийг сумын ИТХ тогтоолоор баталсан төлчин хөтөлбөрт хамрагдсан 50 иргэнд цалин болгон өгсөн

Зүүнхангай сум ОНХС-ийн эх үүсвэрээс аймгийн төвд орон сууц худалдан авахад дэмжлэг 5.4 сая төгрөг зарцуулсан нь сумын ОНХС-ийн эх үүсвэрээс зарцуулахаар хуулиар зөвшөөрөгдсөн төсөл, арга хэмжээнд байхгүй байна. Иймд ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, тогтоомжид нийцүүлэн зарцуулж байхыг зөвлөмж болгов.

2.6. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгосон байна.

ТБОНӨХБАҮХАТ-ын 46.1.6-д “Захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” эрх үүрэгтэй гэж заасан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас худалдан авах ажиллагааг зохион байгуулж шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБГазарт шилжүүлэн хяналтыг хийлгэсэн байна.

Аудитын явцад 2016 онд аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлыг газар дээр нь үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд

Улаангом сумын 10, 12-р багийн 0.4 кв-ын цахилгаан дамжуулах шугамын ажлын барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын 2016 оны 11 сарын 30-ны өдрийн актаар давтан газардуулга 200 м тутам, шугамын трассын эхлэл, төгсгөл хэсэгт хийх, замын зорчих хэсэг тулгуурын татлага хэсэгт туяаруулагч хийх үүрэг даалгавар өгч хүлээн авсан байна.




Комиссын өгсөн үүрэг даалгаварыг биелүүлээгүй байсанд Барилгын тухай хуулийн 12.4-д “Барилгын чанарын баталгаат хугацаа 3 жил байна”, Улаангом сумын 10, 12-р багийн 0.4 кв-ын цахилгаан дамжуулах шугамын ажлыг гүйцэтгэх 2016 оны 11

сарын 03-ны УВТГГН-01/2016 гэрээний 3.2-т "Буруу буюу дутуу хийсэн ажлаа тухай бүр өөрийн хөрөнгөөр засаж гүйцээн, ажлын явцад зөрчил дутагдлыг шуурхай арилгаж угсарсан тоног төхөөрөмжиндөө тохируулга хийж найдвартай ажиллагааг хангана. Мөн "Гэрээний тусгай нөхцлийн 32-т "Чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуулийн дагуу 3 жил байна" 35-д "Гүйцэтгэсэн ажлын баталгаа болох барьцаа хөрөнгийн хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 5% байх бөгөөд барилгын ажлыг ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш 3 жилийн хугацаанд ажлын гологдол, зөрчил гараагүй нөхцөлд буцаан олгоно" гэж заасныг тус тус үндэслэн дээрх дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгэгч "Хос Хан Хөхий" ХХК-аар гүйцэтгүүлэхийг албан шаардлага болгов.

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн халаалт, цэвэр халуун ус хангамж, бохирын системийн засвар өргөтгөлийн 79.0 сая төгрөгийн ажлын барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссийн 2015 оны 11-р сарын 9-ний өдрийн актаар 2016 оны хавар дутуу ажлыг хийж гүйцэтгэх үүрэг өгч хүлээн авсан байна. Гадна хийсэн бохирын цооногоос бохир үнэртдэг, хальж гадагшилдаг, ойр ойрхон дүүрдэг, хуучин цооногтой ил шаланкаар холбосон байдалтай байна.



Тухайн ажлын зургийг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэнтэй хянан үзүүлэхэд шинээр хийсэн бохирын худгаас хуучин цооногийн хооронд 26 м урттай Ф150 мм PVC хоолойгоор газар доогуур 0,008 i уналттай, элсэн дэвсгэртэй холболт хийхээр тусгагдсан байна.



Барилгын тухай хуулийн 12.4-д "Барилгын чанарын баталгаат хугацаа 3 жил байна", Улаангом сумын 1-р цэцэрлэгийн халаалт, цэвэр ус хангамж, бохирын системийн засварын ажил гүйцэтгэх 2015 оны 10-р сарын 13-ны дугаар УВБЗА-10/2015 гэрээний 3.2-т "Буруу буюу дутуу хийсэн ажлаа тухай бүр өөрийн хөрөнгөөр засаж гүйцээн, ажлын явцад зөрчил дутагдлыг шуурхай арилгаж угсарсан тоног төхөөрөмжиндөө тохируулга хийж найдвартай ажиллагааг хангана. Мөн "Гэрээний тусгай нөхцлийн 32-т "Чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуулийн дагуу 3 жил байна" 35-д "Гүйцэтгэсэн ажлын баталгаа болох барьцаа хөрөнгийн хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 5% байх бөгөөд барилгын ажлыг ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш 3 жилийн хугацаанд ажлын гологдол, зөрчил гараагүй нөхцөлд буцаан олгоно" гэж

заасныг тус тус үндэслэн дээрх дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгэгч “Олон баригаг” ХХК-аар гүйцэтгүүлэхийг албан шаардлага болгов.

Бөхмөрөн сумын Гурван жигэртэй багийн мал угаалгын ванны ажлыг 2016 оны 11-р сарын 7-нд хүлээн авах комисс ажиллаж ус алдаж байсныг 2017 хавар засварлах чиглэл өгч хүлээн авч гэрээний санхүүжилт 6.5 сая төгрөгийг бүрэн олгосон байна. Ванны засварын ажлыг гүйцэтгэгч компаниар хийлгэхийг албан шаардлага болгов.

Цаашид барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авахдаа комиссоос хугацаатай үүрэг өгсөн нөхцөлд үүргийн биелэлтэнд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг зөвлөмж болгож байна.

Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоосон”-ыг зөрчин аймгийн баяр наадамд 2016 онд 30.0 сая төгрөг зарцуулсан байна. Цаашид Засгийн газрын 2010 оны 271 тоот тогтоолоор баталсан хэмжээг мөрдөж ажиллахыг албан шаардлага болголоо.

Улаангом сумын ОНХС-аас иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний шинэчлэл төсөл гэж 45.0 сая төгрөг төлөвлөн баталсныг мөн төлөвлөгөөнд тусгагдсан Улаангом сумын 6,9-р багийн ЦДАШ татах ажлын санхүүжилтад зарцуулсан байна.

ОНХС-ийн эх үүсвэр сүүлийн жилүүдэд танагдаж ирснээс шалтгаалан санхүүжилт он дамжин дутуу олгогдож 2016 оны жилийн эцсийн байдлаар дараах өр төлбөр үүссэн байна. Үүнд:

Аймгийн ОНХС-ийн 415.2 сая:

- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 24.9 сая
- Концессын гэрээний дагуу ДДТ-1, ДДТ-7-с хэрэглэгч хүртлэх гадны шугам татахад эхний дэмжлэг 260.1 сая
- Галдан бошигт хорооллын гадна инженерийн цахилгаан хангамж, дэд өртөөний ажил 19.7 сая
- Ахмадын сувилалын барилгын гадна цахилгаан дамжуулах агаарын шугам дэд өртөөний ажил 39.0 сая
- Наадмын талбайн авто зогсоолын барилгын ажлын зөрүү 71.4 сая

Сумдын ОНХС-ийн 334.0 сая:

- Улаангом сум Гиваан баатарын талбайн тохижилт 85.0 сая, нэгдсэн хогийн цэгийн ЦДАШ татах 10.0 сая, 6, 9-р багийн ЦДАШ татах 13.7 сая, байрнуудын дундах тоглоомын талбайн тохижилт 28,9 сая, нийтийн тээврийн үйлчилгээний дэмжлэг 11.1 сая, өвс тэжээлийн үлдэгдэл 0.9 сая, зураг төсвийн үлдэгдэл 7.2 сая, хур хог цэвэрлэх 7.0 сая, эрүүл мэнд хөтөлбөр 11.7 сая, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж 10.0 сая, Улиасны хэвийн цэвэр усны худгийн үлдэгдэл 8.5 сая, морь барианы газрын худгийн үлдэгдэл 6.0 сая, Бадрахын гудамжийн явган хүний зам 24.2 сая, газар чөлөөлөх мөнгө 10.9 сая, нийт 235.1 сая
- Давст сум цэцэрлэгт хүрээлэн 1.9 сая, зургийн үнэ 3.0 сая, нийт 4,9 сая
- Завхан сум нисэх хорооллын 0.4 шугамын шинэчлэл 31.7 сая
- Зүүнговь сум 10 квт-ын шугам татах, 250 кв дэд өртөө барих ажил 5.0 сая, халуун усны барилга 0.5 сая, нийт 5.5 сая
- Малчин сум тэжээлийн нөөц бүрдүүлэх 6.2 сая, худаг гаргах, засвар үйлчилгээ 0.2 сая, нийт 6.4 сая
- Наранбулаг сум цахилгаан шугамын өргөтгөл 14.7 сая
- Өмнөговь сум Баянгол багийг эрчим хүчинд холбох 10.0 сая, утасгүй интернет 5.3 сая, нийт 15.3 сая
- Тэс сум тэжээлийн нөөц бүрдүүлэх 5.7 сая
- Өлгий сум интернетийн шилэн кабель 14.7 сая

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын санхүүжилт хасагдаж ирснээс 2016 онд аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээс хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс нийт 33 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

2.7. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана”, Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан журмын 8.6-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн

хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ” гэж заажээ. Гэтэл ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хийгдсэн зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсныг данс бүртгэлд тусгахыг албан шаардлага болгов. Үүнд:

- ✓ Зүүнхангай сум ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн Тэгш буянт багт хадлангийн талбай хаших 5.0 сая, Даланбулаг багт бодын хашаа 2.0 сая, Баянгол багийн хашаа засвар 1.2 сая, нийт 8.2 сая
- ✓ Цагаанхайрхан сум Морьтын зам дагуух газрын төлөвлөлтийн зураг 13.0 сая
- ✓ Тариалан сум Соёлын төвийн засварын зураг төсөвт 9.0 сая төгрөг төлөвлөж 5.0 сая төгрөг зарцуулсан байна. Тухайн зураг төсвийг засварын ажилд ашиглаагүй бөгөөд данс бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын явцад зарим сум ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байсныг тусгуулсан. Тухайлбал:

- ❖ Өлгий сум интернетийн сүлжээ 19.8 сая
- ❖ Зүүнговь сум гэрэлтүүлэг 10.0 сая, Ахлах сургуулийн коридорын шал 13.9 сая, нийт 23.9 сая
- ❖ Малчин сум ЗДТГ-ын зочид буудлын засварын ажил 6.0 сая,
- ❖ Өндөрхангай сумын Жингийн голын гүүр ОНХС-ийн эх үүсвэрээр хийхээр төлөвлөн баталсныг хандиваар гүйцэтгүүлсэн 8.0 сая
- ❖ Хяргас сум ном, авъяас хөтөлбөрийн хүрээнд авсан ном 0.2 сая

Мөн Хяргас сум малжуулах төслийн зээлийн 21.0 сая төгрөгийг авлагаар тусгаагүй байсныг аудитын явцад санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хөрөнгийг зориулалтаар нь ашиглахгүй байгаа дараах зөрчил илэрсэнд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахыг зөвлөлөө. Үүнд:

- ✓ Бөхмөрөн сумын Дунд сургуульд сургалтын тоног төхөөрөмж худалдан авах 10.0 сая төгрөгийн төслийн хүрээнд авсан дотуур байрны камерыг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан боловч суурилуулж ашиглаж эхлээгүй
- ✓ Тариалан сумын ОНХС-ийн 3.5 сая төгрөгийн эх үүсвэрээр бэлтгэсэн малын эмчилгээ үйлчилгээний зөөврийн хашааг айлын малын хашаа болгон ашиглуулж байгаа
- ✓ Баруунтуруун сумын Хүүхдийн цэцэрлэг 2.0 сая төгрөгөөр худалдан авсан тоглоомыг ашиглахгүйгээр Хилийн цэргийн 0311 ангийн агуулахад хадгалж байгаа

Аудитын явцад сумдад ажиллахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Амны хөндийн эрүүл мэнд” төслийн хүрээнд бэлтгэсэн шүдний ховил битүүлэгч түрхлэгийн хугацаа 2017 оны 3 дугаар сард дуусахаар байсан. Ихэнх сумдад үлдэгдэлтэй байгаа нь ОНХС-ийн хөрөнгө үргүй зарцуулагдах эрсдэл үүсгэж байсан тул аймгийн Эрүүл мэндийн газарт шаардлагатай арга хэмжээг авч хариуг 2017 оны 4 дүгээр сарын 1-ний дотор ирүүлэх тухай аймгийн Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудиторын 2017 оны 3 дугаар сарын 13-ны 21 тоот албан бичиг хүргүүлсэн.



Тухайн асуудлаар аймгийн Засаг дарга болон ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга нарын зүгээс 2016 оны 7, 9 дүгээр саруудад аймгийн Эрүүл мэндийн газар болон сумдын ЭМТ-ийн эрхлэгч эмч нарт “Сийлант” арга

хэмжээг өөрийн нөөц бололцоог дайчлан зохион байгуулах, үлдсэн материалын хугацааг бэлтгэн нийлүүлэгч “Дэс” компанитай холбогдож яаралтай сунгах арга хэмжээ авах талаар албан тоотуудыг хүргүүлж байсан байна.

Манай байгууллагаас хүргүүлсэн тоотын хариуг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ны 215 тоотойр шаардлагатай арга хэмжээг авч, судалгаа гарган ирүүлсэн байна. Судалгаанаас үзэхэд аймгийн хэмжээнд анх 1561 ширхэг шприц материалыг 85.8 сая төгрөгөөр худалдан авсан бөгөөд 711 ширхэг 39.1 сая төгрөгийн материалыг 2016 онд түрхсэн байна. Харин 2017 онд нэмж 134 ширхэг 7.4 сая төгрөгийн материалыг сумуудад түрхсэн байна. Улаангом сумын материалын үлдэгдлээс 2016 онд 200 ширхэг 11.0 сая төгрөгийн материалыг “Дэс” ХХК-д буцаасан, 2017 оны 4 сарын 26-ны байдлаар сумдуудад нийт 516 ширхэг 28.4 сая төгрөгийн материалын үлдэгдэлтэй байгаа нь үргүй зардал болох эрсдэл үүсээд байна.

“Сийлант” арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн түрхлэгийн үлдэгдлийн талаар аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтнээс тодруулахад дараах тайлбар өгсөн.

ЭМГ-ийн статистикийн хэлтсээс Увс аймгийн хэмжээнд нийт 19492 хүүхдийг хамруулахаар судалгаа гаргаж өгсөн. Тэдгээр хүүхдийн 62406 шүдэнд сийлант хэрэглэхээр тооцсон бөгөөд 6 настай хүүхдийн 2 шүд, 7-17 настай хүүхдийн 4 шүдэнд түрхэх тооцоог АШУИС-ийн хүүхдийн нүүр амны өвчнөөс урьдчилан сэргийлэх тэнхимийн эрдэмтэн, профессоруудтай хамтарч хийсэн. Сийлант үйлдвэрлэгч Ультрадент компанийн 1 шприц материалыг 35-40 шүдэнд хүрэлцдэг гэсэн зааврын дагуу тооцооллыг хийж материалын захиалга өгсөн. Гэвч түрхлэг хийхэд уг материал 1 нь хамгийн багадаа 80 шүдэнд, хамгийн ихдээ 140 шүдэнд хэрэглэгдэж байсан. Шалтгаан нь:

1. Үйлдэврлэгчийн заавраас 2-3.5 дахин их шүдэнд хэрэглэгдэж байгаа нь Увс аймгийн хүүхдийн байнгын араа шүдний ховилын хэмжээ жижиг
2. Нэг удаа 1 шприцыг шууд хэрэглэхэд хорогдол гарахгүй байх магадлалтай
3. Үзлэгийг дахин хийх албан бичгийг удаа дараа хүргүүлсэн боловч арга хэмжээ зохион байгуулаагүй
4. Нэгдсэн эмнэлгийн оролцоо сул хамтран ажиллаагүй
5. Сумуудад албан бичиг хүргүүлэн илүү гарсан материалын хугацааг сунгах ажлыг зохион байгуулахыг мэдэгдсэн ч арга хэмжээ аваагүй

Цаашид нийтийг хамарсан төсөл арга хэмжээг зохион байгуулахдаа судалгаа шинжилгээ, нөөц бололцоондоо тулгуурлан тодорхой цаг хугацааг нарийн төлөвлөн хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахдаа Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан шууд худалдан авч болох жишиг үнийг баримтлаагүй байна.
2. Аймаг, зарим сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим төсөл, арга хэмжээний гэрээ, техникийн тодорхойлолт шаардлага хангахгүй байна.
3. Аймаг, сумдын ОНХС-аас хуулиар тогтоосон чиг үүрэгт байхгүй, багийн иргэдээс санал аваагүй зарим ажлыг эрэмбэлж, төлөвлөгөөнд тусгаж санхүүжүүлсэн байна
4. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээс төсөл, хөтөлбөр нэрээр урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.
5. Зарим сумууд ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн өвс, тэжээлийг үнэ төлбөргүй болон 50 хувиар хямдруулан олгосон байна.
6. ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн өвс, тэжээлийн авлага 8 суманд 38.4 сая төгрөг байна.
7. Барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах комисс ажлын гүйцэтгэлд хугацаатай үүрэг өгч хүлээн авсан байна.
8. ОНХС-ийн эх үүсвэр сүүлийн жилүүдэд танагдаж ирснээс шалтгаалан санхүүжилт он дамжин дутуу олгогдож 2016 оны жил эцсийн байдлаар аймаг 415.2 сая, сумууд 334.0 сая төгрөгийн өртэй байна.
9. ОНХС-ийн эх үүсвэрээр бий болсон зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.
10. Сумуудад “Сийлант” арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн нийт 516 ширхэг 28.4 сая төгрөгийн материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Зөвлөмж: Увс аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат, Засаг дарга Д.Батсайхан,сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт:

1. Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан шууд худалдан авч болох жишиг үнийг баримтлах
2. ТБОНӨХБАҮХАТ-ын хуулийн 11-р зүйлд заасан “Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд тавигдах шаардлагыг мөрдөж ажиллах”.
3. Төсвийн тухай хуулийн 60.3.1, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан зааврын 4.2, 4.4, 4.6 дэх заалтуудыг мөрдөж ажиллах.
4. Өвс, тэжээлийн авлагыг барагдуулах.
5. Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс хугацаатай үүрэг өгч хүлээн авсан ажлын үүргийн биелэлтэнд тавих хяналтыг сайжруулах.
6. ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын санхүүжилтийн өрийг барагдуулах.
7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын зүйл заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаж байх.
8. ОНХС-ийн эх үүсвэрийг бодит тоо судалгаанд үндэслэн төлөвлөж байх, үргүй зардал гаргахгүй байх.

Бүлэг 3: ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.

3.1. ОНХС-ийн хэрэгжилтийн явцад аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт хийгээгүй, дотоод аудитын алба хяналт шалгалт хийсэн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана”, 9.4-д “Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын “Орон нутгийн төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангаж, аж ахуйн харилцаанд шудрага өрсөлдөөнийг буй болгох, төсвийн хувиарилалт, зарцуулалт, хөрөнгө оруулалт, орлого бүрдүүлэлт, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх, төрийн ба орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зээл тусламжийн үр ашиг, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, худалдан авалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавих, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудын тэнцвэртэй хөгжлийг хангах, дэд бүтэц зам тээвэр, барилга байгууламж, хот тосгоны төлөвлөлт, эрчим хүч, уул уурхай, харилцаа холбооны салбарын хөгжил зэрэг асуудлыг эрхлэх” чиг үүрэгтэй Төсөв, санхүү эдийн засгийн, хөгжлийн хороо ажиллаж байна.

2016 онд аймгийн ИТХ-ын “Төсөв, санхүү эдийн засгийн, хөгжлийн хороо” болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд аймгийн ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Улаангом сумаас бусад сумдын ИТХ-ын дэргэд хяналтын хороо байгуулаагүй байна. 2016 онд сумуудын ИТХ-ын зүгээс ОНХС-ийн эх үүсвэрийн зарцуулалтанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 14.2.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй”, 69 дүгээр зүйлд дотоод аудитын чиг үүргийг тусгажээ.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.2-д “ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ”, 9.6-д “ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд орон нутгийн дотоод аудитын болон иргэдийн хөндлөнгийн хяналт тавина. Орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын тайланг дотоод аудитын тайлангийн хамт Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр залруулга, арга хэмжээг авна” гэж заасан байна.

Аймгийн ЗДТГ-ын санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 онд төлөвлөгөөт 9 сумын 2014, 2015 оны ОНХС-ийн зарцуулалтыг хяналт, шалгалтанд хамруулсан байна.

Сангийн яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас системчилсэн шалгалт ирэхэд ЗДТГ-ын санхүүгийн хяналт, аудитын алба хамтран аймгийн ОНХС-ийн 2014, 2015 оны зарцуулалтанд хяналт хийсэн байна.

3.2. Сумууд ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу ирүүлээгүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1-д “Сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын

хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна” гэж заасан байхад сумууд 2016 оны ОНХС-ийн хагас, бүтэн жилийн тайланг аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст ирүүлээгүй байна. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн талаар жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг томилогдоогүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1 дэх заалт хэрэгжихгүй байгаатай холбоотойгоор 10.2-д “Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ”, 10.3-д “Аймаг нийслэлийн ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст ирүүлнэ” гэсэн заалтууд хэрэгжихгүй байна.

Харин “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11.2.4-д “Аймаг, нийслэл, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн, сумын төрийн сангийн мэргэжилтэн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг тухай бүр системд оруулж бүртгэнэ” гэж заасны дагуу аймаг болон сумуудын ОНХС-ийн санхүүжилтийн мэдээллийг ОНХС-ийн дотоод серверт бүрэн оруулсан байна.

3.3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна”, Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 6-ны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11.2.3-д “Аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь Тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж байна” гэж заажээ.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэдээллийн самбарт 2016 онд аймгийн ОНХС-аар хийгдсэн ажлын санхүүжилтийн мэдээллийг жилийн дүнгээр байршуулсан, ихэнх сумын ЗДТГ-ын мэдээллийн самбарт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр анх төлөвлөн баталсан ажлын жагсаалтыг байршуулсан байх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж байршуулах ажил хангалтгүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөгөө ө, тайлан, санхүүжилтийн мэдээллийг цахим сайтад дараах байдалтай мэдээлсэн байна. Тухйалбал:

- uvstender.mn сайтад 2015, 2016 онд хийгдэх ажлын төлөвлөгөө аймаг, сумдаар, худалдан авах ажиллагааны 2016 оны төлөвлөгөө, тайлан, тендерийн урилга, үр дүн, бусад холбогдох мэдээ, мэдээлэл
- shilendans.gov.mn сайтад ОНХС-ийн орлого, зарлагын санхүүжилтийн сар бүрийн мэдээ, тайлан
- uvs.gov.mn сайтад ОНХС-ийн 2015 оны 10 сар хүртлэх төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээлэл байршуулсан байна.

Цаашид цахим сайтад болон мэдээллийн самбарт ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг хууль журамд заасны дагуу тухай бүр шинэчлэн байршуулж хэвшихийг зөвлөж байна.

3.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжийн зарим заалттай нийцэхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 58.2.11-д “Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх ажилд “Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх” гэж заасан байхад Сангийн сайдын 2014 оны 43 тоот зааврын 7.2.7-д “аймгийн ОНХС-ийн хэрэгжүүлэх ажилд Иргэдийг нийтийн тээврийн үйлчилгээгээр хангах машин техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах /Сэлбэг хэрэгсэл худалдан авах, **урсгал зардал** хамаарахгүй/” гэсэн заалтууд нийцэхгүй байна. Нийтийн тээврийн үйлчилгээний зардал нь сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй байхад Улаангом сум нийтийн тээврийн үйлчилгээнд гэж 32.4 сая төгрөг төлөвлөн 21.5 сая төгрөг зарцуулсан байна. Аймгийн хэмжээнд Улаангом сумын ЗДТГазар нийтийн тээврийн үйлчилгээний асуудлыг эрхлэж байна.

Түүнчлэн “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа хэдий ч зарим зүйл заалтын хэрэгжилт хангалтгүй, зарим зүйл заалтыг шинэчлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Зааврын 11.2.4-д “Аймаг, нийслэл, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн, сумын Төрийн сангийн төлөөлөгч ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг тухай бүр системд оруулж бүртгэнэ” гэж заажээ. Гэтэл Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг үндэслэн Сумын Засаг даргын Тамгын газарт сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлт хариуцсан Санхүүгийн албыг байгуулсан байна. Тухайн албанд төрийн сангийн төлөөлөгч гэсэн орон тоо байхгүй байна.

- Зааврын 9-р зүйл “ОНХС-ийн хяналт, шинжилгээ ба үнэлгээ”, 10-р зүйл “ОНХС-ийн тайлагналт”-ын хэсгийн хэрэгжилт хангалтгүй байна.

- Зааврын 4.9-д “ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон өмчийн урсгал зардлын тооцоо цаашид төсөвт хэрхэн нөлөөлөх болон урсгал зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал туссан байх” гэж заасан байна. Аудитын явцад сумдаар ажиллахад ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон өмчийн урсгал зардлын тодорхой хувийг ОНХС-ийн эх үүсвэрээс нь зарцуулах боломжтой болгох талаар санал хүсэлт гаргаж байна.

3.5. Өмнөх оны аудитаар өгсөн актыг 100 хувь, албан шаардлагыг 85.7 хувь, зөвлөмжийг 50 хувь хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

№	Зөвлөмжийн утга	Биелэлтийн хувь
1	Төсвийн тухай хуулийн 58-р зүйл, Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримталж ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлах.	50%
2	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 30-р тогтоолын дагуу бүрэн шилжүүлэх.	50%
3	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалын зүйл заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаж байх.	50%
4	Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр, арга хэмжээг батлахдаа хийгдэх ажлыг тодорхой нэрчлэн тусгаж байх.	50%
5	ТБОНӨХБАҮХАТ-ын хуулийн 11-р зүйлд заасан “Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд тавигдах шаардлагыг мөрдөж ажиллах”.	50%
6	ТБОНӨХБАҮХАТ хуулийн зүйл заалтыг мөрдөж ажиллах,	50%

захиалагчаас тавих хяналтыг сайжруулах..

Өмнөх оны аудитаар өгсөн 1 акт, 7 албан шаардлагыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

№	Төлбөрийн акт	Биелэлтийн хувь
1	Түргэн сумын ОНХС-д төвлөрүүлсэн сумын ойн хандиваас иргэн Н.Дариймаад зээл хэлбэрээр 2500.0 мянган төгрөг өгснөөс 2000.0 мянган төгрөгийг төлөөгүй	100%
	Актын биелэлт	100%
	Албан шаардлага	
1	Тариалан суманд 2015 онд ашиглалтанд орсон 10.0 сая төгрөгийн өртөгтэй сайжруулсан шороон зам, Соёлын төвд хандиваар хийсэн 3.0 сая төгрөгийн засвар, худагны засварын 2.0 сая төгрөг, нийт 15.0 сая төгрөгийн ажлыг хүлээн авсан ч данс бүртгэлд тусгаагүй	100%
2	Ховд суманд 2014 оны 7 сард ашиглалтад оруулсан 39.5 сая төгрөгийн өртөгтэй нэмэлт дэд станцын баталгаат хугацаа дуусаагүй байхад трансформатораас тос хаяж хэвийн ажиллагаа алдагдах, бүрэн ажиллагаагүй болох нөхцөл бүрдсэн	0%
3	Өлгий суманд 2014 оны 8 сард ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулсан 77999.3 мянган төгрөгийн өртөгтэй “Б.Гиваан баатрын хөшөөт талбайг барих” ажлыг бүрэн хийж хүлээлгэн өгөөгүй, Эрүүл мэндийн төвд 3000.0 мянган төгрөг тоног төхөөрөмж нийлүүлэхэд байгуулсан гэрээнд ямар тоног төхөөрөмж, хэдэн төгрөгөөр нийлүүлэх нь тодорхойгүй, малжуулахад зориулан иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 2013 онд 6 малчинд 18000.0 мянга, 2014 онд 6 малчинд 18000.0 мянга, 2015 онд 7 малчинд 18000.0 мянга, нийт 19 малчинд 54000.0 мянган төгрөг олгохдоо зээлийн гэрээ байгуулаагүй	100%
4	Малчин сумын Наадмын талбайн засварын ажлыг 2015 оны 6-р сард хүлээлгэн өгсөн ч төв асрын дээвэр салхинд хуурч, нурсан	100%
5	Баруунтуруун сум 3,6 сая төгрөгийн өртөг бүхий спорт заалны засварын ажлын зураг төсвийг данс бүртгэлд тусгаагүй	100%
6	Өлгий сумын Соёлын төвийн эрхлэгч С.Хүдэрбат ажлын цагаар ажлын байран дээрээ удаа дараа байхгүй, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхгүй аудитын ажилд саад учруулсан	100%
7	Өмнөговь сумын Засаг даргын орлогч Ш.Лхагвасүрэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам зааврыг мөрдөөгүй, Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй, албан ажилдаа хариуцлагагүй хандсан	100%
	Албан шаардлагын биелэлт	85,7%

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. ОНХС-ийн хэрэгжилтийн явцад аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт хийгээгүй байна.
2. Сумууд ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу ирүүлээгүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна
3. Өмнөх оны аудитаар өгсөн актыг 100 хувь, албан шаардлагыг 85.7 хувь, зөвлөмжийг 50 хувь хэрэгжүүлсэн байна.

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Зөвлөмж: Увс аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат, Засаг дарга Д.Батсайхан, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт:

1. Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 6-ны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1, 10.1 дэх заалтуудыг мөрдөж ажиллах.

Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл

Таны оршин суугаа газар	Дүн
1. Хороо_____	Увс
2. Сум_____	17
3. Дүүрэг/Аймаг_____	
4. Таны нас_____	
5. Хүйс: 1.Эрэгтэй	217
2. Эмэгтэй	275
6. Боловсролын байдал_____	
7. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн ямар төсөл арга хэмжээ Танай хороо, сум, дүүрэгт хэрэгжиж буй талаар Та хэр мэдээлэлтэй байна вэ?	
1. Санхүүжүүлж буй үйл ажиллагааны жагсаалт, хэрэгжилтийг сайн мэднэ	213
2. ОНХС-аас төсөл, арга хэмжээ санхүүжүүлдэг гэж сонссон, харин манай сум, дүүрэгт ямар арга хэмжээ хэрэгжиж буйг мэдэхгүй	170
3. Энэ талаар огт мэдээлэл байхгүй	96
8. ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх баг, хорооны иргэдийн нийтийн хуралд Та оролцож байсан уу?	
1. Байнга	114
2. Хааяа	230
3. Огт үгүй	148
9. Хэрвээ оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлуудыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар Таны бодол?	
1. Цаанаасаа бэлтгэсэн асуудлуудын жагсаалтыг хэлэлцүүлж санал авдаг	101
2. Оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг	135
3. Дээрх хоёр аль аль нь	90
4. Иргэдийн саналыг бараг сонсдоггүй, нэр төдий хурал болдог	102
10. ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг уу?	
1. Тийм	224
2. Зарладаг байх, гэхдээ би сонсоогүй	161
3. Огт үгүй	68
11. ОНХС-аас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас Танай өрхөд ирж байсан уу?	
1. Саналын хуудас, мэдээлэл байнга ирдэг	117
2. Санал хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл өгдөг	187
3. Санал хуудас ирдэггүй, мэдээлэл ч өгдөггүй	145
12. ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтад иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юу?	
1. Бүрэн боломжтой	200
2. Боломжгүй	92
3. Энэ талаар мэдэхгүй байна	163
13. ОНХС-ийн санхүүжилт, төсөл арга хэмжээний талаарх Таны нэмэлт санал хүсэлт?	163

Холбогдох байгууллагын санал


**УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**
213400, Улаангом, Увс аймаг
Регистр: 9062858 ш/х: 267
Утас/Факс: 70452113

2017.04.28 № 128
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, Аймгийн Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалт"-д хийсэн нийцлийн Аудитын тайлантай танилцлаа. Уг нийцлийн аудит хийхдээ аймаг болон бүх сумдыг хамруулсан байна.

Танай хийсэн нийцлийн аудитын дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байна. Тайлантай холбоотой гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА  Э.НАСАНБАТ

001120



АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

УВС АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213400 Улаангом, Увс аймаг
Утас/ Факс: (01452) 7045-2012

2017.05.01 № 6/516
танай _____-ны № _____-т

Тайлангийн төслийн тухай

Танай газраас ирүүлсэн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлд дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. Төслийн 1.3-т тусгагдсан 8 сумын хувьд тухайн сумдын нутаг дэвсгэрт хайгуул хийсэн компаний нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг ашигт малтмалын төлбөрийн орлого гэж буруу ойлгуулснаас дээрх орлогыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн нэг эх үүсвэр гэж үзжээ. Энэ нь төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.6, 60.2.7 дахь заалтад заасан эх үүсвэрийн орлого биш юм.

2. Төслийн 1.4-т тусгагдсан дүн нь зарим сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хийж гүйцэтгэсэн байдлыг харгалзан үзсэн болно.

Зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ЭРДЭНЭСҮРЭН

2 0114

My doc: tamgin gazar A-4



**УВС АЙМАГ
УЛААНГОМ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

213400, Улаангом, Увс аймаг

Утас/Факс: 7045-3030

2017.05.01 № 372

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, Аймгийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалтанд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Танай хийсэн аудитын дүгнэлт зөвлөмжтэй санал нэг байна. Тайлантай холбоотой гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА  Ц.ПҮРЭВЖАВ

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналын хариу.

- Аймгийн ИТХ: “Нийцлийн аудитын дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байна. Тайлантай холбоотой гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно” гэсэн санал ирүүлсэн байна.
 - Аймгийн Засаг дарга: Дараах санал ирүүлсэн байна.
1. Тайлангийн төслийн 1.3-т тусгагдсан 8 сумын хувьд тухайн сумдын нутаг дэвсгэрт хайгуул хийсэн компани нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг ашигт малтмалын төлбөрийн орлого гэж буруу ойлгуулснаас дээрх орлогыг сумын ОНХС-ийн нэг эх үүсвэр гэж үзжээ. Энэ нь төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.6, 60.2.7 дахь заалтад заасан эх үүсвэрийн орлого биш юм.
 2. Төслийн 1.4-т тусгагдсан дүн нь зарим сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хийж гүйцэтгэсэн байдлыг харгалзан үзсэн болно.

Дээрх ирүүлсэн саналын дагуу тайлангийн холбогдох хэсэгт өөрчлөлт оруулан тусгасан болно.

- Улаангом сумын Засаг дарга: “Нийцлийн аудитын дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байна. Тайлантай холбоотой гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно” гэсэн санал ирүүлсэн байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АХЛАХ ШИНЖЭЭЧ
АУДИТОР

С.АЛТАНХУНДАГА
М.БАТСУУРЬ
Т.НАМЖИЛ